



МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРАЛ Г.ПҮРЭВДОРЖ ТАНАА

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын Газрын Харьга Төв Аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГазар байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Дарга, тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273204

Шинжээч Ц.Хишигжаргал
И-мэйл khj_616@yahoo.com
Утас: 70273463
Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудит хийж дууссан тухай мэдэгдэл

АГУУЛГА

ХУУДАС

- Танилцуулга 3
- Санхүүгийн дотоод хяналт ... 4
- Гол шийдлүүд 4-6
- Залруулаагүй алдаа7
- Тайлбар мэдүүлгийн захидал..... 7
- Аудитын санал дүгнэлт 7

**Мах боловсруулах үйлдвэрийн 2013 оны
санхүүгийн тайланд аймгийн Аудитын
газар аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГазрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дуусаж байна. Зуунмод сумын Мах боловсруулах үйлдвэрийн захиралд энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мах боловсруулах үйлдвэрийн удирдлага нь тухайн зөвлөмж бүрд хариу ирүүлэхийг бид хүсэж байна.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Санхүүгийн гол хяналтууд

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, зээл болон санхүүжилт, борлуулалтын орлого, ашиг алдагдал, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Илрүүлсэн гол зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулвал:

- Тайлант оны орлого, зардлыг тодорхой хэмжээгээр төлөвлөсөн боловч эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс бүрэн хүчин чадлаар ажиллаагүй улмаар алдагдалтай ажилласан байна.
- Бараа материалын тайланг НББүртгэлийн программаар хөтөлж, өртөг болон худалдах үнээр данс бүртгэлд тусгаж, ашиг алдагдлыг тодорхой тайлагнах шаардлагатай байна.
- Цех болон дэлгүүрийн борлуулалтын орлого болон зардлын тооцоог бодоогүй ашиг алдагдлыг тооцоогүй байна.
- Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 21-ны өдрийн 176 тоот тушаалаар батлагдсан төсөвт байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллах журмыг мөрдөж ажиллах

Ерөнхий менежер, санхүүгийн ажилтнаас Аймгийн Аудитын газар тайлбар мэдүүлэг хүлээж байна.

-Илэрсэн алдааг хэрхэн залруулах талаар тайлбар ирүүлнэ үү

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд болон аудитын газарт ирүүлсэн тайлбарыг үндэслэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага бичиж, хязгаарлалттай дүгнэлт гаргуулахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа Тэргүүлэх Аудитор 2014 оны 03 дугаар сарын 24 өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад бидний ажилд байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж байсанд гүнээ талархаж байна.

Аймгийн Аудитын газар

2014-03-20

Танилцуулга

Бид Мах боловсруулах үйлдвэрийн 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дуусаж байна. Мах боловсруулах үйлдвэрийн захиралд энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна.

Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мах боловсруулах үйлдвэрийн удирдлага нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- НББ-ийн боловсруулалт, төсөвт байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй хууль, журам, заавар, аргачлалын хэрэгжилт болон аудитын явцад гарсан сул талууд болон түүнийг хэрхэн шийдвэрлэсэн эсэхээ дахин шалгах зэрэг ажлуудыг хийлээ.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГазрын санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатай гэж үзсэн. Бидний дахин шалгалт нь Мах боловсруулах үйлдвэрийн хэрэгжүүлж буй хяналтыг ААГ-аас тооцож гаргасан санхүүгийн эрсдэл ба хяналтын байвал зохих горимтой харьцуулан үзсэн. Үүний үр дүнд зайлшгүй удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байгааг тогтоосон. Бид удирдлагад тухайн жилд дотоод хяналтад гарсан сул талуудын тухай мэдэгдсэн.

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Мах боловсруулах үйлдвэр нь 2013 онд Дотоод хяналт шалгалтын комисс томилоогүй хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

2. Орлого, санхүүжилтийн талаар

Тайлант онд аймаг хөгжүүлэх сангаас зээл 50000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлого 90518.7 мянган төгрөг, актын төлбөрөөс болон бусад орлого 15934.3 мянган төгрөг бүгд 156453.0 мянган төгрөгийн эх үүсвэртэйгээр тайлагнасан байна. Үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогыг 394479.2 мянган төгрөгөөр баталсан ба мөнгөн гүйлгээний тайлангаар 106453.0 мянган төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 27.0 хувьтай байна. МБҮйлдвэр нь 2013 онд 4856.7 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч 119352.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Тайлант оны орлого, зардлыг тодорхой хэмжээгээр төлөвлөсөн боловч эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс бүрэн хүчин чадлаар ажиллаагүй улмаар алдагдалтай ажилласан байна.

3. Үндсэн хөрөнгө

Тайлант онд Үндсэн хөрөнгө 1260051.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг дансаар авч үзвэл:

Барилга байгууламж: 516000.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан 15025.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Авто тээврийн хэрэгсэл: 20500.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан 3075.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тоног төхөөрөмж: 717298.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан 45808.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тавилга хэрэгсэл: 6253.9 мянган төгрөгөөр тайлагнагдсан 938.1 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсан байна байна.

- Тайлант онд үндсэн хөрөнгөд элэгдэл байгуулж эхэлсэн ба нийт 64846.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд тусгасан байна.

4.Бараа материал

Бараа материалын тодруулга тайлангаар оны эхэнд махны үлдэгдэл 39658.2 мянган төгрөг, орлого 109339.3 мянган төгрөг, зарлага 116159.3 мянган төгрөг, оны эцэст 32838.2 мянган төгрөг байна. Хангамжын материал оны эхэнд 3042.9 мянган төгрөг, орлого 19187.4 мянган төгрөг, зарлага 17828.2 мянган төгрөг, оны эцсэст 4402.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бэлэн бүтээгдхүүнд 748.0 мянган төгрөг орлого 34670.1 мянган төгрөг, зарлага 35220.5 мянган төгрөг үлдэгдэл 197.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мал амьтан дансан 6600.0 төгрөгийн мал байсан дээр 450.0 мянган төгрөгийн орлого авч 4140.0 мянган төгрөгийн зарлага гарсан байна. Жилийн эцэст бараа материалын дансанд тооллого хийж тооцоог бодсон байна.

- Бараа материалын тайланг НББүртгэлийн программаар хөтөлж, өртөг болон худалдах үнээр данс бүртгэлд тусгаж, ашиг алдагдлыг тодорхой тайлагнах шаардлагатай байна.

5.Цалингийн талаар

Цалин, шимтгэлийн зардал нь мөнгөн гүйлгээний тайлангаар 36643.4 мянган төгрөг, үр дүнгийн тайлангын тодруулгаар 46838.8 мянган төгрөг буюу 10195.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. цалингаас ХАОАТатвар болон НДШимтгэлийг зөв тооцоолж суутгасан ба байгууллагаас НДШимтгэлийг зөв тооцож шилжүүлсэн байна. Нядалгааны ажил ихтэй буюу ачаалал ихтэй үед гэрээгээр ажилчид авч ажиллуулдаг ба тогтмол цалин олгодог байна.

- Ажиллагсдын цалинг зөв тооцоолж олгосон боловч үр дүнгийн тайлангийн тодруулгад буруу тусгасан байна.

6.Бараа үйлчилгээний зардал

Мөнгөн гүйлгээний тайлангаар бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 155222.5 мянган төгрөг гүйцэтгэлээр 51162.0 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 104060.5 мянган төгрөгөөр хэмнэсэн мэт байна. Борлуулсан бүтээгдхүүний өртөг 64564.1 мянган төгрөг нь нийт зардлын дүнд орж тооцогдсон байна. Орлого үр дүнгийн тайлангаас зардлын зүйлээр авч үзвэл ажиллагсадын цалинд 31683.2 мянган төгрөг, НДШимтгэлд 4960.2 мянган төгрөг, ашиглалтын зардалд 4989.7 мянган төгрөг, тээвэр шатахуунд 8813.7 мянган төгрөг шуудан холбоонд 293.9 мянган төгрөг, аймаг хөгжүүлэх сангаас авсан зээлийн хүүд 665.0 мянган төгрөг, бусад зардалд 65.2 мянган төгрөг нийт 51162.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

- Цех болон дэлгүүрийн борлуулалтын орлого болон зардлын тооцоог бодоогүй ашиг алдагдлыг тооцоогүй байна.

7.Мөнгөн хөрөнгө

Тайлант онд харилцах данс болон кассын эхний үлдэгдэл 1339.5 мянган төгрөг байсан дээр нийт 156453.0 мянган төгрөгийн орлогын 141924.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарч мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь 15867.7 мянган төгрөг байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар ажилагчдад олгосон мөнгө 31683.2 мянган төгрөг, НДШимтгэлд 4960.2 мянган төгрөг, ашиглалтын зардалд 4989.7 мянган төгрөг, түүхий эд бараа материал худалдан авахад 90762.7 мянган төгрөг, түлш шатахуун, сэлбэгийн зардалд 8813.7 мянган төгрөг, зээлийн хүүд 665.0 мянган төгрөг бусад зардалд 65.2 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Бэлэн мөнгөний кассын тайлангаас харахад кассанд их хэмжээний мөнгө үлдэгдэлтэй байхад харилцахаас мөнгө татаж авдаг, сар, улирал, жилийн эцэст кассын үлдэгдэлийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байгаа нь бэлэн мөнгөний зарцуулалт болон тайлагнал бодитой биш байгааг харуулж байна.

- Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 21-ны өдрийн 176 тоот тушаалаар батлагдсан төсөвт байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллах журмыг мөрдөж ажиллах

8.Авлага ,өглөгийн талаар

Оны эхэнд 17124.1 мянган төгрөгийн авлагатай байсан ба үүнээс аудитын актаар 13280.0 мянган төлбөр болгосоноос 11415.7 мянган төгрөгийг барагдуулж 1864.3 үлдсэн ба нийт 7245.4 мянган төгрөгийн авлагатай гэж тайлагнасан байна. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж авлагыг баталгаажуулсан байна.

Тайлант оны эхэнд аймаг хөгжүүлэх санд 65700.0 мянган төгрөгийн зээлийн өглөгтэй байсан дээр дахин 50000.0 мянган төгрөгийн зээл авч 115.7 сая төгрөгийн зээлийн өглөгтэй болсон байна. Мөн Татварын хэлтэст 76.7 мянган төгрөг, НДХэлтэст 910.5 мянган төгрөгийн өглөгтэй гэж тайлагнагдсан байна.

- Авлага өглөгийг багасгах зохион байгуулалттай арга хэмжээ авч ажлаагүй байна.
- Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГазар нь үйл ажиллагааны үр дүнд ашигтай ажиллаж өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах ёстой байтал жил бүр аймаг хөгжүүлэх сангаас зээл авч өглөг нэмэгдэж байгаа нь тус байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

Бидний шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Аудитын газарт НББүртгэлийн стандартад нийцээгүй, дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж тамга дараагүй, албан ёсоор баталгаажуулаагүй, канондож хуулбарласан Санхүүгийн тайланг авчирсан болно.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитын явцад алдаа залруулагдаагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ ЕМ-ээс эдгээр баталгааг бичгээр авсан байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас Мах боловсруулах үйлдвэрийн санхүүгийн тайланд **хязгаарлалттай** дүгнэлт өгөх санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014-03-20